



ЦЭНХЭР СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

1

**Аудитын код: АРА-
2017/14/СТА-ТТЗ**

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70333141
Цахим хаяг:

Аудитын менежер:
Утас: 70332860
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Архангай
аймгийн Аудитын газар
Байршил: Эрдэнэбулган сум
Цахим хуудас:
www.audit.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3: Менежмент захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэл

Агуулга

1		0
2	Аудитын гэрчилгээ	2
3	Аудитын тайлан	3
3.1	Оршил	3
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
3.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
3.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
3.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
3.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
3.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
3.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
3.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
3.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
3.11	Шилэн дансны мэдээлэл	9
3.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
3.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
4	Менежментийн захидал	10
4.1	орлого	11
5	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	12
5.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
5.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
5.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
5.4	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
5.5	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	22

1 Аудитын гэрчилгээ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Цэнхэр сумын төсвийн ерөнхийлөн захирагч Б.Батжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Цэнхэр сумын ТЭЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цэнхэр сумын ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.10 - наас 2017.03.25 – ны хооронд хийж, аудитын тайланг 2017.03.25 - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ахлах аудитор Н.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Цэнхэр сумын ТЭЗ 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.03.07 - нд төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Цэнхэр сумын ТЭЗ “Монгол улсын ЗЗНДТУТХуулийн 18.1 дэх хэсэгт “Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд өөрийн эрхлэх хүрээний асуудлыг онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Цэнхэр сумын ТЭЗ дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Цэнхэр сумын ТЭЗ “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэд хүнд сурталгүй аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно.” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Цэнхэр сумын ТЭЗ нь дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан Төсвийн орлогын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангилал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралтыг 341 дүгээр тушаалаар батлан тус бүр мөрдөн ашиглаж байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цэнхэр сумын ТЭЗ төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж дүгнэгдлээ.

Цэнхэр сумын ТЭЗ санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Plastic” программ хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Цэнхэр сумын ТЭЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 17 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.5 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд , 1 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 3 “бага” байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг сонгон авсан шалтгаан нь тухайн байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзлээ.

Цэнхэр сумын ТЭЗ 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3516.1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 35.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 2 чиглэлээр 2 эрсдэлтэй асуудалд 2 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 50 хувь буюу 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дахь залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	96.2	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	2	96.2	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитаар сумын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн талаар дараахь зөрчил илэрлээ.

- Цэнхэр сумын ИТХ-ын 2016.12.10-ны өдрийн 15 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг **246.9** сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр **626.9** сая төгрөг төвлөрч нийт дүнгээрээ **123.7** сая төгрөгөөр давсан буюу орлогын гүйцэтгэл 253 %-тай биелэсэн хэдий ч орлогын нэр төрлөөр үзэхэд 9 нэр төрлөөр 0.3-351.8 сая төгрөгөөр давж, 5 нэр төрлөөр 0.06-2.3 сая төгрөгөөр буюу **5.9** тасарсан нь орлогын төлөвлөлт оновчгүй, шахуу төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.
- Мөн Сумын ИТХ-ын 2016.12.10-ны өдрийн 15 тоот тогтоолоор сум хөгжүүлэх сангийн орлогыг **130.0** сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр **39.7** сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө **30.5** хувьтай байгаа бөгөөд орлогын төлөвлөгөө **90.3** сая төгрөгөөр тасарсан байна.

- **Шийдвэрлэсэн нь:** Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах, орлого тасарч, давж байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох, Төсвийн тухай хуулийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах
Мөн Сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөнд онцгой анхаарч холбогдох арга хэмжээг авч ажиллах тухай зөвлөмжүүдийг хүргүүлэх

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Цэнхэр сумын Засаг дарга өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 2231.9 сая, хөрөнгийн зардалд 281.2 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2641.1	2489.3	94.2%	151.8
1.1	Урсгал зардал	2231.9	2160.9	96.8%	71.0
1.2	Хөрөнгийн зардал /ОНХС+ бусад/	281.2	246.6	87.7%	34.5
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл /СХС/	128.0	81.7	63.8	46.3

Тайлант оны төсвийн гүйцэтгэл 94.2 хувьтай байна. Төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү **151.8** сая төгрөг байна. Энэ нь төсөвт байгууллагуудын хэмнэгдсэн үлдэгдэл буюу төвлөрүүлэх шилжүүлэг **86.9** сая төгрөг / үүнд ОНХС- Тендерийн баримт бичгийн үнэ 0.4 сая төгрөг, / , орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл **19.0** сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн дутуу санхүүжигдсэн **46.3** сая төгрөг тус тус зөрүүтэй харагдаж байна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016.10.03-ны өдрийн 08 тоот тогтоолоор батлагдсан сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө **30.5** хувьтай байгаагаас орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна гэж үзэхэд хүргэж байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт **38.4** сая төгрөг зарцуулагдсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Цэнхэр сумын ТЭЗ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Цэнхэр сумын ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрын 12 тоот тогтоолоор орлогын төлөвлөгөөг 179.3 сая төгрөгөөр батласан ч 689.7 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 4 дахин давж биелэсэн хэдий ч 6-н нэр төрлийн орлого 0.3-15.3 сая төгрөгөөр тус тус тасарсанд аудитаас

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах
- Орлого тасарч байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох зөвлөмж хүргүүлсэн боловч биелүүлж ажиллаагүй энэ онд мөн л орлого нэр төрлөөрөө тасарсан байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цэнхэр сумын ТЭЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цэнхэр сумын ТЭЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж **“Зөрчилгүй”** санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.9-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг бус, материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цэнхэр сумын ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг дансдаар ангилан үзүүлэв.

3.1 ОРЛОГО

Илрүүлэлт

- Цэнхэр сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 15 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг 246.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 626.9 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 253 %-иар биелэсэн хэдий ч 5 нэр төрлөөр 0.06-2.3 сая төгрөгөөр буюу 5.9 тасарсан, 9 нэр төрлөөр 0.3-351.8 сая төгрөгөөр давсан байгаа нь орлогын төлөвлөлт оновчгүй, шахуу төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.
- Мөн Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар 10-ны өдрийн 15 тоот тогтоолоор сум хөгжүүлэх сангийн орлогыг **130.0** сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр **39.7** сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө **30.5** хувьтай байгаа бөгөөд орлогын төлөвлөгөөг **90.3** сая төгрөгөөр тасалсан байна.

Зөвлөмж

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах
- Орлого тасарч, давж байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох
- Төсвийн тухай хуулийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах
- Сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөнд **онцгой** анхаарч холбогдох арга хэмжээг авч ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Эрсдэл

- Сумын ИТХ-аар баталсан Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө орлогын нэр төрлөөр биелэгдээгүйгээс санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байх
- Орон нутгийн Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдэхгүй байх

Зөвлөмжийг биелэлтийг 2017.06.15-ны дотор албан тоотоор ирүүлнэ үү

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,133,570,748.38	1,116,596,026.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	649,374,602.16	561,653,793.12
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	649,374,602.16	561,653,793.12
31210	Төгрөг	649,374,602.16	561,653,793.12
31211	Төрийн сангийн харилцах	528,384,100.86	483,080,125.16
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	120,990,501.30	78,573,667.96
33	АВЛАГА	332,665,362.38	374,593,237.34
33500	Бусад авлага	332,665,362.38	374,593,237.34
33510	Байгууллагаас авах авлага	27,058.38	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	332,638,304.00	374,593,237.34
35	БАРАА МАТЕРИАЛ	151,530,783.84	180,348,995.69
35100	Түүхий эд материал	112,469,374.97	135,082,998.47
35110	Тусгай зориулалттай материал	108,966,303.56	134,016,731.64
35130	Эм боох материал	3,503,071.41	1,066,266.83
35400	Хангамжийн материал	38,531,420.87	45,265,997.22
35410	Бичиг хэргийн материал	2,266,101.00	5,037,841.00
35420	Аж ахуйн материал	9,665,548.82	12,338,478.82
35440	Түлш, шатах тослох материал	4,587,071.10	11,753,081.10
35450	Барилгын засварын материал	6,684,180.00	2,495,080.00
35460	Хүнсний материал	9,586,864.45	2,327,860.80
35470	Бусад хангамжийн материал	5,741,655.50	11,313,655.50
35600	Мал амьтад	529,988.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,117,303,779.98	3,364,928,471.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,117,303,779.98	3,364,928,471.19
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	3,117,303,779.98	3,364,928,471.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,566,469,814.48	4,761,349,814.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,054,205,168.17	-2,142,830,260.13
39203	Авто-тээврийн хэрэгсэл	250,689,390.00	365,119,910.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-94,928,917.55	-120,352,620.95
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	376,138,713.97	465,078,122.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	-163,749,682.17	-217,587,732.62

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	142,196,314.60	160,142,425.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-80,518,280.83	-91,102,555.74
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	8,500,000.00	8,500,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	196,706,823.00	222,706,823.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-43,034,066.83	-61,123,827.67
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	13,038,839.48	15,028,372.63
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,250,874,528.36	4,481,524,497.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,250,874,528.36	4,481,524,497.34
51	Засгийн газрын хувь оролцоо	4,250,874,528.36	4,481,524,497.34
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,425,606,294.21	1,392,938,667.95
51200	Хуримтлагдсан үр дүн	891,525,494.60	1,154,843,089.84
51210	Өмнөх үеийн үр дүн	999,186,409.63	924,193,120.86
51220	Тайлант үеийн үр дүн	-107,660,915.03	230,649,968.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,933,742,739.55	1,933,742,739.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,250,874,528.36	4,481,524,497.34

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,231,020,306.89	3,746,265,267.65
11	ТАТВАРЫН ОРЛОГО	647,578,130.62	620,122,011.30
110	Орлогын албан татвар	21,793,380.00	33,536,281.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	21,545,380.00	33,536,281.30
110002	Үйл ажиллагааны орлого	21,425,380.00	32,605,281.30
110004	Хөрөнгө борлуулсны орлого	120,000.00	931,000.00
113	Хөрөнгийн албан татвар	794,000.00	2,850,000.00
113002	Бууны албан татвар	794,000.00	2,850,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	624,990,750.62	583,735,730.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	34,334,889.00	33,364,780.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,862,889.00	4,840,380.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	72,000.00	36,400.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	30,400,000.00	28,488,000.00
1181	Газрын төлбөр	1,688,000.00	2,042,000.00
118102	Дуудлага худалдаа	1,688,000.00	2,042,000.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	588,967,861.62	548,328,950.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	31,670,825.00	42,486,450.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	430,000.00	840,000.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	14,239,648.00	15,577,500.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	542,627,388.62	489,425,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	199,337,912.27	363,724,168.35
120	Нийтлэг татварын бус орлого	199,337,912.27	363,724,168.35
120002	Хүүгийн орлого	0.00	270,000.00
120003	Торгуулийн орлого	37,874,875.00	9,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	158,634,690.27	357,973,938.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,670,900.30	3,053,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,375,000.00	10,308,712.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	140,588,789.97	344,611,726.35
120009	Бусад орлого	2,828,347.00	5,470,630.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,384,104,264.00	2,762,419,088.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,500,862,799.00	1,623,273,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	0.00	104,047,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,500,862,799.00	1,519,226,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,881,677.00	38,378,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доо д шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,881,677.00	38,378,880.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	809,143,300.00	1,015,217,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	443,693,600.00	874,009,900.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	235,449,700.00	141,208,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	130,000,000.00	0.00
1330	Төсвийн захирагчдаас	17,216,488.00	83,704,711.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	0.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,216,488.00	83,704,711.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	1,844,097.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	1,844,097.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,830,575,026.57	3,516,145,286.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,705,549,925.57	3,305,495,758.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,074,293,267.57	2,169,607,520.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,359,374,131.00	1,328,616,028.00
210101	Үндсэн цалин	1,251,675,397.00	1,133,106,255.00
210102	Нэмэгдэл	14,241,398.00	67,115,392.00
210104	Урамшуулал	47,038,056.00	76,551,378.00
210105	Гэрээт ажлын хөлс	46,419,280.00	51,843,003.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,671,335.62	145,805,128.00
210201	Тэтгэврийн даатгал	95,459,025.00	92,954,974.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,483,694.62	10,566,731.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,601,485.00	13,208,813.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,924,023.00	2,641,986.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,203,108.00	26,432,624.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,090,167.00	84,024,928.00
210301	Гэрэл, цахилгаан	15,084,351.00	17,398,997.00
210302	Түлш, халаалт	67,201,406.00	64,880,231.00
210303	Цэвэр, бохир ус	1,804,410.00	1,745,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,978,150.80	81,304,983.50
210401	Бичиг хэрэг	8,055,175.80	10,772,530.00
210402	Тээвэр, шатахуун	28,344,395.00	46,674,474.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,183,280.00	10,502,900.00
210404	Ном, хэвлэл	401,200.00	423,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,045,000.00	4,143,320.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,949,100.00	6,172,387.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	2,616,272.50
2105	Нормативт зардал	115,734,099.75	128,982,783.23
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,511,078.50	26,231,635.58
210502	Хоол, хүнс	96,388,053.25	96,357,857.65
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,834,968.00	6,393,290.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,581,890.00	26,239,392.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,423,700.00	4,890,242.00
210602	Тавилга	179,100.00	0.00
210604	Урсгал засвар	6,979,090.00	21,349,150.00
2107	Томилолт, зочны зардал	5,920,040.00	7,443,700.00
210702	Дотоод албан томилолт	5,920,040.00	7,443,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,410,175.00	14,575,573.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,759,125.00	12,522,993.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	415,000.00	330,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	210,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,050.00	771,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	8,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	300,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,748,000.00	643,130.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	290,533,278.40	352,615,004.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,852,324.79	155,037,123.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	704,420.00	1,017,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	229,976,533.61	196,560,881.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	631,256,658.00	1,135,888,238.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	142,207,446.00	136,343,059.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0.00	1,844,097.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,753,454.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,673,140.00	28,610,482.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,265,900.00	53,115,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч дад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,233,502.00	28,956,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,281,450.00	23,816,580.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1,923,953.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,923,953.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	478,773,838.00	996,983,583.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	443,693,600.00	912,639,100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,080,238.00	84,344,483.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,275,374.00	637,643.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,275,374.00	637,643.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	125,025,101.00	210,649,528.00
2200	Дотоод эх үүсвэрээр	125,025,101.00	210,649,528.00
220001	Барилга байгууламж	10,000,000.00	45,527,328.00
221001	Их засвар	98,037,900.00	165,122,200.00
222001	Тоног төхөөрөмж	16,987,201.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	400,445,280.32	230,119,980.98
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	529,988.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	0.00	529,988.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	29,942,345.59	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	29,942,345.59	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	370,502,934.73	230,649,968.98

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,942,097,210.62	3,450,239,064.96
11	ТАТВАРЫН ОРЛОГО	647,578,130.62	620,122,011.30
110	Орлогын албан татвар	21,793,380.00	33,536,281.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	21,545,380.00	33,536,281.30
110002	Үйл ажиллагааны орлого	21,425,380.00	32,605,281.30
110004	Хөрөнгө борлуулсны орлого	120,000.00	931,000.00
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ х увиараа эрхлэгч	248,000.00	0.00
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ х увиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	248,000.00	0.00
113	Хөрөнгийн албан татвар	794,000.00	2,850,000.00
113002	Бууны албан татвар	794,000.00	2,850,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	624,990,750.62	583,735,730.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	34,334,889.00	33,364,780.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,862,889.00	4,840,380.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	72,000.00	36,400.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	30,400,000.00	28,488,000.00
1181	Газрын төлбөр	1,688,000.00	2,042,000.00
118102	Дуудлага худалдаа	1,688,000.00	2,042,000.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	588,967,861.62	548,328,950.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	31,670,825.00	42,486,450.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	430,000.00	840,000.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	14,239,648.00	15,577,500.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	542,627,388.62	489,425,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,693,622.00	585,008,896.66
120	Нийтлэг татварын бус орлого	51,693,622.00	585,008,896.66
120003	Торгуулийн орлого	37,874,875.00	9,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,990,400.00	579,528,666.66
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,615,400.00	42,798,566.66
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,375,000.00	10,507,500.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	0.00	526,222,600.00
120009	Бусад орлого	2,828,347.00	5,470,630.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,242,825,458.00	2,245,108,157.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,500,862,799.00	1,480,596,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,500,862,799.00	1,480,596,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,277,677.00	38,378,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доо д шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,277,677.00	38,378,880.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	643,708,800.00	631,672,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	278,259,100.00	386,416,600.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	235,449,700.00	141,208,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	130,000,000.00	104,047,500.00
1330	Төсвийн захирагчдаас	17,216,488.00	83,704,711.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,216,488.00	83,704,711.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	29,759,694.00	10,755,766.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	29,759,694.00	10,755,766.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,312,828,730.00	3,126,570,187.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,312,828,730.00	3,126,570,187.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,669,656,737.00	1,981,226,515.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,243,955,927.00	1,327,716,028.00
210101	Үндсэн цалин	1,129,753,213.00	1,133,106,255.00
210102	Нэмэгдэл	20,745,378.00	78,141,143.00
210104	Урамшуулал	47,038,056.00	75,651,378.00
210105	Гэрээт ажлын хөлс	46,419,280.00	40,817,252.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,722,580.00	145,805,128.00
210201	Тэтгэврийн даатгал	87,040,880.00	92,954,974.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,588,758.00	10,566,731.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,421,863.00	13,208,813.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,827,222.00	2,641,985.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,843,857.00	26,432,625.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,254,390.00	95,649,450.00
210301	Гэрэл, цахилгаан	13,796,074.00	17,384,597.00
210302	Түлш, халаалт	55,629,906.00	76,319,153.00
210303	Цэвэр, бохир ус	1,828,410.00	1,945,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,632,510.00	70,953,099.00
210401	Бичиг хэрэг	3,174,500.00	7,471,850.00
210402	Тээвэр, шатахуун	20,437,630.00	40,034,212.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,205,000.00	11,118,100.00
210404	Ном, хэвлэл	608,430.00	659,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,349,500.00	2,436,590.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,857,450.00	9,232,647.00
2105	Нормативт зардал	113,830,949.00	116,432,950.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,767,383.00	22,530,795.00
210502	Хоол, хүнс	97,415,886.00	87,087,009.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,647,680.00	6,815,146.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,462,720.00	17,585,320.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,769,600.00	2,547,670.00
210602	Тавилга	3,184,000.00	5,590,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	260,000.00	0.00
210604	Урсгал засвар	2,249,120.00	9,447,650.00
2107	Томилолт, зочны зардал	5,429,040.00	7,443,700.00
210702	Дотоод албан томилолт	5,429,040.00	7,443,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,038,719.00	18,127,795.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,150,669.00	16,075,215.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	330,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	210,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,050.00	771,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	8,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	300,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	643,130.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,329,902.00	181,513,045.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,726,332.00	169,550,885.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,603,570.00	11,962,160.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	643,171,993.00	1,145,343,672.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	166,215,196.00	145,798,493.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	29,759,694.00	10,755,766.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,412,450.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,693,700.00	29,154,247.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,265,900.00	53,115,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч дад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,233,502.00	28,956,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	849,950.00	23,816,580.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,987,823.00	83,573,341.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,987,823.00	83,573,341.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	453,968,974.00	915,971,838.00
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	443,693,600.00	912,639,100.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,275,374.00	3,332,738.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	629,268,480.62	323,668,877.96
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	15,629,500.00	0.00
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	15,629,500.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	132,104,301.00	329,689,687.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	132,104,301.00	329,689,687.00
2200	Дотоод эх үүсвэрээр	132,104,301.00	329,689,687.00
220001	Барилга байгууламж	10,000,000.00	45,527,328.00
221001	Их засвар	98,037,900.00	165,242,450.00
222001	Тоног төхөөрөмж	16,987,201.00	119,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,079,200.00	118,799,919.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-116,474,801.00	-329,689,687.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ЭНИЙ ДҮН	0.00	-81,700,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	81,700,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	0.00	81,700,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	512,793,679.62	-87,720,809.04
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	136,580,922.54	649,374,602.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	649,374,602.16	561,653,793.12

4.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгө

өр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,641,111,800.00	2,489,280,049.00	151,831,751.00	94.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,231,903,000.00	2,160,925,291.00	70,977,709.00	96.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,087,947,100.00	2,025,882,564.00	62,064,536.00	97.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,329,775,000.00	1,327,270,953.00	2,504,047.00	99.81
210101	Үндсэн цалин	1,134,783,500.00	1,133,106,255.00	1,677,245.00	99.85
210102	Нэмэгдэл	67,194,400.00	78,141,143.00	-10,946,743.00	116.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	0.00	0.00
210104	Урамшуулал	76,346,300.00	75,651,378.00	694,922.00	99.09
210105	Гэрээт ажлын хөлс	51,450,800.00	40,372,177.00	11,078,623.00	78.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,275,000.00	145,552,728.00	722,272.00	99.51
210201	Тэтгэврийн даатгал	93,084,500.00	92,702,574.00	381,926.00	99.59
210202	Тэтгэмжийн даатгал	10,638,200.00	10,566,731.00	71,469.00	99.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,297,600.00	13,208,813.00	88,787.00	99.33
210204	Ажилгүйдлийн даатгал	2,659,300.00	2,641,985.00	17,315.00	99.35
210205	Эрүүл мэндийн даатгал	26,595,400.00	26,432,625.00	162,775.00	99.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,660,900.00	95,649,450.00	11,450.00	99.99
210301	Гэрэл, цахилгаан	17,384,600.00	17,384,597.00	3.00	100.00
210302	Түлш, халаалт	76,321,300.00	76,319,153.00	2,147.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,955,000.00	1,945,700.00	9,300.00	99.52
210304	Байрны түрээс	0.00	0.00	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,063,200.00	58,758,424.00	304,776.00	99.48
210401	Бичиг хэрэг	5,484,000.00	5,483,450.00	550.00	99.99
210402	Тээвэр, шатахуун	35,199,700.00	34,926,462.00	273,238.00	99.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,357,500.00	11,348,100.00	9,400.00	99.92
210404	Ном, хэвлэл	1,228,900.00	1,219,700.00	9,200.00	99.25
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,436,800.00	2,436,590.00	210.00	99.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,356,300.00	3,344,122.00	12,178.00	99.64
2105	Нормативт зардал	117,091,900.00	116,432,950.00	658,950.00	99.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,530,800.00	22,530,795.00	5.00	100.00
210502	Хоол, хүнс	87,744,400.00	87,087,009.00	657,391.00	99.25
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,816,700.00	6,815,146.00	1,554.00	99.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,263,800.00	13,564,520.00	3,699,280.00	78.57
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,550,000.00	2,547,670.00	2,330.00	99.91
210602	Тавилга	7,000,000.00	3,544,200.00	3,455,800.00	50.63
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00	0.00	0.00
210604	Урсгал засвар	7,713,800.00	7,472,650.00	241,150.00	96.87
2107	Томилолт, зочны зардал	6,506,000.00	6,343,700.00	162,300.00	97.51
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	6,506,000.00	6,343,700.00	162,300.00	97.51
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,515,700.00	19,084,665.00	1,431,035.00	93.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,683,600.00	17,675,215.00	1,008,385.00	94.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	330,000.00	70,000.00	82.50
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	0.00	150,000.00	0.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	772,100.00	771,450.00	650.00	99.92
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	8,000.00	52,000.00	13.33
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	0.00	150,000.00	0.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00	0.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	300,000.00	0.00	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	295,795,600.00	243,225,174.00	52,570,426.00	82.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	288,183,500.00	235,613,614.00	52,569,886.00	81.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,612,100.00	7,611,560.00	540.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,955,900.00	135,042,727.00	8,913,173.00	93.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,955,900.00	135,042,727.00	8,913,173.00	93.81
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,154,300.00	29,154,247.00	53.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,115,400.00	53,115,300.00	100.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,133,000.00	28,956,600.00	176,400.00	99.39
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,553,200.00	23,816,580.00	8,736,620.00	73.16
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	281,208,800.00	246,654,758.00	34,554,042.00	87.71
220001	Барилга байгууламж	56,208,800.00	45,527,328.00	10,681,472.00	81.00
221001	Их засвар	215,000,000.00	192,528,050.00	22,471,950.00	89.55
222001	Тоног төхөөрөмж	10,000,000.00	8,599,380.00	1,400,620.00	85.99
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	128,000,000.00	81,700,000.00	46,300,000.00	63.83
230001	Эргэж төлөгдөх зээл	128,000,000.00	81,700,000.00	46,300,000.00	63.83
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,641,111,800.00	2,463,683,387.66	177,428,412.34	93.28
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,480,596,700.00	1,477,395,432.00	3,201,268.00	99.78
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,480,596,700.00	1,477,395,432.00	3,201,268.00	99.78
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	490,464,100.00	406,759,289.00	83,704,811.00	82.93
320001	Орон нутгийн төсвөөс	386,416,600.00	302,711,789.00	83,704,811.00	78.34
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	104,047,500.00	104,047,500.00	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	670,051,000.00	579,528,666.66	90,522,333.34	86.49
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	133,760,000.00	42,798,566.66	90,961,433.34	32.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,907,100.00	10,507,500.00	-2,600,400.00	132.89
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	528,383,900.00	526,222,600.00	2,161,300.00	99.59
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	123,151,823.30	-123,151,823.30	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	97,555,161.96	-97,555,161.96	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,087.00	1,118.00	-31.00	102.85
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7.00	7.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	7.00	7.00	0.00	100.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00	0.00	0.00
62	АЖИЛЛАГАСДЫН ТОО	148.00	179.00	-31.00	120.95
620001	Удирдах ажилтан	7.00	9.00	-2.00	128.57
620002	Гүйцэтгэх ажилтан	90.00	116.00	-26.00	128.89
620003	Үйлчлэх ажилтан	36.00	42.00	-6.00	116.67
620004	Гэрээт ажилтан	15.00	12.00	3.00	80.00

4.5 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
3	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,392,938,667.95	1,934,774,439.08	-355,647,986.82	2,972,065,120.21
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	32,667,626.26	14,976,488.83	432,014,582.58	479,658,697.67
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,425,606,294.21	1,949,750,927.91	76,366,595.76	3,451,723,817.88
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-16,008,188.36	444,705,962.76	428,697,774.40
7	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	-49,998.65	-49,998.65
8	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	370,502,934.73	370,502,934.73
10	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,425,606,294.21	1,933,742,739.55	891,525,494.60	4,250,874,528.36
11	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,425,606,294.21	1,933,742,739.55	891,525,494.60	4,250,874,528.36
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-32,667,626.26	0.00	32,667,626.26	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,392,938,667.95	1,933,742,739.55	924,193,120.86	4,250,874,528.36
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
18	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	230,649,968.98	230,649,968.98
19	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,392,938,667.95	1,933,742,739.55	1,154,843,089.84	4,481,524,497.34